



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №7

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 06 дугаар сарын 01 нээс 07 дугаар сарын 01 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 06 дугаар сарын 01 нээс 07 дугаар сарын 01 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэн.

Тохиолдол 1:

Камбоджи улсын Сиём Реап мужид 6 сарын 23 нд 41 настай эмэгтэй өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр өвдсөн ба, 5 өдрийн дараа хөрш зэргэлдээ айлын 46 настай эмэгтэй, 16 настай хүү, 7 сарын 01 нд 36 настай эмэгтэй тухайн мужид нэмж бүртгэгдсэн. Тархвар судлалын холбогдлоор хүүхдийн гэрийн ойролцоо тахиа, нугас зэрэг шувууд өвчилж байсан.

Тохиолдол 2:

БНХАУ-н Хэнань, Сичуан, Хунан мужид 52 настай эмэгтэй, 6 настай хүү, 72 настай эмэгтэй сул хоруу чанартай шувууны томуугийн H9N2 хэвшинжээр, Өвөр Монголд 70 настай эмэгтэй H10N3 хэвшинжээр халдвар авсан.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 06 дугаар сарын 01 нээс 07 дугаар сарын 01 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Бельги, Бразил, Камбоджи, Канад, БНХАУ, Финланд, Дани, Герман, Ирланд, Япон, Недерланд, Перу, Норвеги, Польш, Их Британи зэрэг 17 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 134 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Америк тивийн улс оронд цахлай, шувууны аж ахуй, үхрийн фермд, Европ, Зүүн Азийн улс оронд ихэвчлэн хэрээ, цахлай, тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдсэн.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй, үхрийн ферм	8
H5	Бельги	Мөнгөлөг цахлай	3

H5N1	Бразил	Нугас	5
H5N1	Камбоджи	Тахианы аж ахуй, хүний өвчлөл	7
H5N1	Канад	Хэрээ	2
H5N1	Дани	Мөнгөлөг цахлай	1
H5N1	Герман	Тахианы аж ахуй, тодорхойгүй	1
H5N1	Финланд	Цахлай	1
H5N1	Япон	Хэрээ	57
H5N1	Недерланд	Галуу, цахлай, Хун	21
H5N5	Норвеги	Цахлай	1
H5	Польш	Цахлай	1
H5N1	Перу	Шувууны аж ахуй, хотон	5
H5N1	БНСУ	Нугас	1
H9N2, H10N3	БНХАУ	Хүний өвчлөл	4
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, Галуу	15

Зураг 1. 2025 оны 06 дугаар сарын 01 нээс 07 дугаар сарын 01 ний хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

